



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
Төрийн Өмчит Хувьцаат Компани

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Төмөр замын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 18 дугаар зүйлийн 18.3.3, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.11, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэл, Зам, тээврийн хөгжлийн яамны 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 06/3033 албан тоот бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанийн Төмөртэй өртөөний үйл ажиллагаанд дагаж мөрдөх орон нутгийн харилцааны ачаа тээвэрлэлтийн тариф хэрэглэх дүрмийг хавсралтаар баталж 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Төмөртэй өртөөний үйл ажиллагаанд энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг Өртөөний дарга О.Амарсанаад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хэлтсийн дарга А.Төгөлдөр, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга Б.Энэрэлт нарт даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/77 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН
ТӨМӨР ЗАМ
Х.ХЭРЛЭН
УТА 655 0214203

Х.ХЭРЛЭН

000297

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2016 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 1/93 тоот тушаалын хавсралт



**“МТЗ” ТӨХК-ИЙН ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ АЧАА
ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТАРИФ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ**

1. Энэхүү тарифыг вагоны болон чингэлгээр ачаа тээвэрлэсний болон бусад ажил үйлчилгээ үзүүлсний хөлсийг бодож тооцоо хийхэд хэрэглэнэ. Дараах ажил үйлчилгээний тарифуудад НӨАТ ороогүй болно.
2. Тарифын зайг дараах хүснэгтээр тодорхойлно.

№	Өртөө зерлегийн нэр	Байрлал, км	Хоорондын зай, км
1	Төмөртэйн өртөө	0	23.4
2	Хандгайт өртөө	23.4	

3. Ачааны нэр

Ачаа илгээгч нь ачааны нэрийг тодорхойлох уялдуулсан систем (Ачааны нэрсийн жагсаалт)-д заагдсан ачааны нэрстэй тохируулан ачаагаа нэрлэж, кодыг падаанд бичнэ. Ачааны нэрийг хураангуйлах буюу дутуу бичиж болохгүй.

Ачааны нэр дутуу буюу тодорхой бус байвал ачаа илгээх өртөөнд ачааны нэрийг илгээгч тодотгоно. Ачааны нэрийг тодруулж өгөх хүртэл уг ачааг тээвэрлэгч тээвэрлэлтэнд хүлээн авахгүй байж болно. Ачааны нэрийг тодруулах хүртэлх гарсан зардлыг ачаа илгээгч хариуцна.

Ачааны нэр тодорхой бус байгаа нь хүрэх өртөөнд илэрсэн тохиолдолд зөрчлийг ачаа илгээгч зөрчил илрүүлсэн өртөөтэй хамтран шийдвэрлэх бөгөөд үүнтэй холбоотой зардлыг ачаа илгээгч бүрэн хариуцна.

4. Ачааны жин

Тээврийн хөлсийг бодохыг тулд ачааны жинг дараах байдлаар бүхэлчилнэ:

А. Нэг бүлэгт хамааруулсан хэд хэдэн төрлийн ачааг нэг төрлийн ачаа гэж тэдний нийт жинг бүхэл тоонд дэвшүүлэн тооцно.

Б. Ачааны баглаа боодол, тавиур болон бусад хэрэгслийг ачааны нийт жинд оруулж тооцно.

В. Ачааны даацад хүрэхгүй ачааны жинг вагоны даацаар бодож тооцно.

5. Ачааны тээврийн хөлс бодох

Тээвэрлэх ачааны тээврийн хөлсийг тээврийн хөлс бодох 1 вагон.км-ээр тодорхойлов.

Вагон илгээлтийн тээврийн хөлсийг падаанд заасан ачааны нэр, тээвэрлэлтийн зайг үндэслэн энэхүү тарифын дагуу тооцно.

6. Хаяг солигдсон ачааны тээврийн хөлс бодох

Хаяг солилт гэдэг нь илгээгч хүлээн авагчийн бичгэн зөвшөөрлийн мэдэгдлээр хүрэх өртөө, хүлээн авагчийн хаягийг солихыг хэлнэ.

- Тээвэрлэлтэд хүлээн авсан ачаа, илгээх өртөөнөөс хөдлөөгүй үед тээврийн хөлс болон хаяг сольсон хөлсийг хаяг солих хүсэлт гаргасан ачаа илгээгчээс

Вагон бүрээс – 40000₮

Чингэлэг бүрээс – 20000₮

7. Ачаа, вагоны тухай ачаа илгээгч болон хүлээн авагчид мэдэгдэхэд дараах хөлсийг авна.

- А. Утсаар мэдэгдвэл – 500 төгрөг,
- Б. Мессэж, электрон шуудангаар мэдэгдвэл – 300 төгрөг,
- В. Бие хүнээр мэдэгдвэл – тухайн гарсан зардал, төгрөг.

8. Вагон тавилт, таталтын хөлс бодох

А. Тавьж өгөх, татаж авах түүнчлэн вагон тавьж өгсний дараа буюу татаж авахаар зүтгүүрийг хоосон явуулсан хөлсийг зүтгүүр-км тутамд 7670 төгрөгөөр бодож тооцох бөгөөд зүтгүүрийн гаралт бүрт 15,340 төгрөгөөс доошгүй байна.

Б. Салбар замд болон ачилтын зам талбайд дахин сэлгээ хийхэд 30 минутад 32500 төгрөгийн хөлс, 1 цагт 65000 төгрөгийн хөлс хураана. Сэлгээ хийсэн цагийг санамжид найруулагч бичиж тооцооны газарт тушаана. 30 минут хүрэхгүй хугацааг 30 минутаар тооцно.

9. Вагон ашиглалтын хөлс

А. Ачаа хүлээн авагч, илгээгчээс вагон ашиглалтын хөлсийг тооцохдоо “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн вагоны вагон- цаг тутамд 800 төгрөг,

Б. “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн вагоноос бусад гадаад паркийн вагоноос УБТЗ-д мөрдөж байгаа тарифт заасан үнэлгээгээр тооцно. “УБТЗ” ХНН-ийн болон бусад байгууллага, хувь хүн, гадаад паркийн вагонд Төмөртэйн өртөөний ачилтын талбайд тавигдсан ба Ерөө өртөөнд хүлээлгэж өгснөөр санамж хөтөлнө.

В. Вагон ашиглалтын хөлсийг санамжийг үндэслэн тооцох ба цаг хүрэхгүй хугацааг бүтэн цагаар тооцно.

Г. Чингэлгийн ачилтын талбайн хадгалалтын хөлсийг тооцон авахдаа чингэлэг-хоног тутамд 20 тн-д 10000, 40 тонн-д 20000 төгрөгөөр тооцож авна.

10. Ачааны жин, тоо хэмжээг шалгасны хөлс

А. Ачааны жинг вагон пүүгээр шалгасан тохиолдолд ачааны 1 тн хүрэхгүйг 1 тн-оор тооцож вагон тутамд 22420 төгрөг,

Б. Ачаа эзэмшигчийн хүсэлтээр ачааны байдал, тоо хэмжээг шалгасан бол шалгалтанд оролцсон хүн/цаг тутмаас 1000 төгрөгөөр тооцно.

11. Тээврийн бичиг баримт бүрдүүлэлтийн болон бусад маягт, материалын үнэ

А. Тээврийн бичиг баримт бүрдүүлэхэд 235 төгрөг,

Б. Падааны маягт, орон нутгийн 235 төгрөг, олон улсын 590 төгрөг,

В. Элдэв хураамжийн үнэ 118 төгрөг,

Г. Бэхэлгээний үнэ /катинг, тросс, дүнз, палк г.м/-хөлсийг гарсан зардлаар нь,

Д. Ломбоны үнэ 1000 төгрөг Ачааг зассан болон бэхэлсний хөлсийг гарсан зардлаар нь тооцно.

12. Вагон захиалгын хөлс

УБТЗ-ын болон бусад эзэмшлийн вагон захиалаад ачаагүй буцаах тохиолдолд нийт гарсан зардлыг хоёр дахин нугалаж төлнө.

13. Бусад үйлчилгээний хөлс

Энэхүү тарифт заагдаагүй бусад үйлчилгээ үзүүлсэн бол гарах зардлаар нь тооцно.

14. Зам талбай ашиглалтын хөлс

Ачилт буулгалтын зам талбай эзэлгээний хөлсийг 1 вагон хоногт 20000 төгрөгөөр тооцно.

15. Ачааны тээврийн хөлс бодох тооцооны үнэлгээ

Тээврийн зайнаас үл хамааран 1 вагон/км тутамд – 6140 төгрөг /НӨАТ ороогүй/.

16. Хөдлөх бүрэлдэхүүнийг хоосноор тээвэрлэх тээврийн хөлс бодох тооцооны үнэлгээ

Хөдлөх бүрэлдэхүүнийг хоосноор ачилтанд болон буултаас суларсны дараа тээвэрлэх тээврийн хөлсний хэмжээг дараах байдлаар тооцно.
1 вагон/км тутамд- 480 төгрөг /НӨАТ ороогүй/.

17. Хэтрүү овортой болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд аюултай, хортой нөлөөлөл үзүүлэх, улмаар үхэл мөхөлд хүргэх үйлчилгээтэй, төмөр замаар тээвэрлэх, ачилт буулгалт хийх болон хадгалалтын үед төмөр замын төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад ачааг гэмтээх тэсэрч дэлбэрэх, хялбар шатах (аюултай, хортой) ачааны тарифыг тооцохдоо ачаатай тээврийн тарифыг 100%-иар нэмэгдүүлэн тооцно. Илгээх өртөө тээврийн бичиг баримтанд оврын тухай тэмдэглэгээг хийсэн байх ёстой.